



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-11
1. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан сонсох	4-7
2. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль баталсантай холбогдуулан боловсруулсан/	7-11

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 25-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 40 минутад төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Чойжилсүрэн;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Булгантуяа, П.Мөнхтулга, З.Мэндсайхан,
Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Г.Тэмүүлэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг.

Нэг.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн тайлангийн сонсгол явуулсан талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, сонсголын тайланг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал нар танилцуулав.

Нэр дэвшигчийн сонсголын тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: Өвгөнхүүгийн Гэрэлт-Одыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн	10
Татгалзсан	6
Бүгд	16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн “Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль баталсантай холбогдуулан боловсруулсан/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хариулж тайлбар хийв.

Ц.Даваасүрэн: “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	9
Татгалзсан	7
Бүгд	16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 26 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхимд 11 цаг 40 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: 16 гишүүн бүртгүүлсэн. 68.8 хувийн ирцтэй байна. Өнөөдрийн хуралдаанд 64.0 хувийн ирцтэй байна гишүүдийн ирц. Тийм учраас Төсвийн байнгын хорооны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Ирцэд Аубакир гишүүн, Ж.Батжаргал гишүүн, Ж.Баясгалан гишүүн, Г.Ганбаатар гишүүн, Г.Дамдинням гишүүн, Д.Цогтбаатар гишүүн, Д.Батбаяр гишүүн, Д.Батлут гишүүн, Х.Болормаа гишүүн, П.Ганзориг гишүүн, Б.Заяабал гишүүн, Р.Батболд гишүүн, Б.Батцэцэг гишүүн, Ж.Ганбаатар гишүүн, Ц.Даваасүрэн гишүүн, Б.Мөнхсоёл гишүүн нар бүртгэгдсэн байна аа.

Өнөөдрийн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан сонсох.

Хоёрт, хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолын төсөл. Батжаргал гишүүний ахалсан ажлын хэсгээс боловсруулсан анхны хэлэлцүүлэг байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүн байна уу? Алга байна. За хэлэлцэх асуудалдаа орьё.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн тайлангийн сонсголыг хэлэлцэж эхэлье.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2-т Төсвийн байнгын хороо Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус нэг гишүүн санал болгож Улсын Их Хуралд томилохоор заасны дагуу бид нар 4 удаа бас оруулсан байгаа. Энэ удаа мөн амжилтгүй болсон учраас энэ удаа Төсвийн байнгын хорооны 2025 оны 6 сарын 10-ны өдрийн хуралдаанаар олонхын санал авсан Гэрэлт-Одын сонсголыг сая хийж ингээд тайланг оруулж ирж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 122.1, 130.1 дэх заалтын дагуу нэр дэвшсэн сонсголыг хийсэн байгаа товлож 6 сарын 25-ны өдөр. Тэгэхээр энэ сонсгол явуулсан тайланг Улсын Их Хурлын гишүүн Заяабал танилцуулна аа.

Сонсголын тайланг танилцуулгыг нь би эхлээд хийгээдэхье. Дараа нь тайланг нь сонсох юм байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хорооны Санхүүгийн

зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд Өвгөнхүүгийн Гэрэлт-Одын нэрийг дэвшүүлсэн.

Өвгөнхүүгийн Гэрэлт-Од нь 1970 онд төрсөн. 55 настай. 1978-1988 онд Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын 1 дүгээр 10 жилийн сургууль, 1988-1993 онд Монгол Улсын Үндэсний их сургуулийг банкны эдийн засагч мэргэжлээр төгссөн. Бизнесийн удирдлагын магистр докторын зэрэгтэй.

Ажилласан байдал 1993-1994 онд Ардын банкны Сүхбаатар салбарт эдийн засагч, 1994-1996 онд 33 дугаар тооцооны төвийн захирал, 1996-1999 онд Хадгаламж банкны тооцооны 29 дүгээр төвийн захирал, 1997-1998 онд Хадгаламж банкны тооцооны 2 дугаар нягтлан бодогч, 2000-2009 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Санхүүгийн тэнхимийн багш, 2009-2013 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Бизнес консалтинг төвийн захирал, Санхүүгийн тэнхимийн багш, 2013-2019 онд МУИС-ийн Бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхимийн багш, 2019-2024 онд МУИС-ийн Бизнесийн сургуулийн Бизнес консалтинг төвийн захирал, Санхүүгийн тэнхимийн дэд профессор, 2024 оноос одоо МУИС-ийн Бизнесийн сургуулийн Санхүүгийн танхимын эрхлэгчээр ажиллаж байгаа юм байна аа.

Нэр дэвшигч нь ОУВС, Монгол банк, Сангийн яамны хамтарсан макро эдийн засгийн шинжилгээ, Герман ЖДҮ-гийн санхүүгийн удирдлага, ажлын байран дахь сургалт арга зүй, Сангийн яамны Засгийн газрын худалдан авах ажиллагаа, хөрөнгийн үнэлгээ, сурагч, багшийн сургалт мөн Жайкагийн Японы япон менежмент бизнесийн зөвлөх, Төрийн өмчийн хорооны төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны удирдлага, МУИС-ийн компанийн засаглалын үндэсний төвтэй хамтарсан компанийн засаглал зэрэг мэргэжил зэрэг мэргэшүүлэх Олон улсын болон үндэсний сургалтад хамрагдсан туршлагатай байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11.5 дахь хэсэгт орон тооны бус гишүүн нь төрийн улс төрийн албан хаагч, улс төрийн намын удирдах албан тушаалтан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн бүх шатын шүүхийн шүүгч, прокурор, санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдэд ажиллаж байгаа этгээд нэр дэвшүүлэхгүй. Мөн 11.6 дахь хэсэгт гишүүн нь эдийн засаг, банк санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээсээ 5-аас доошгүй жил ажилласан байна. Ял шийтгэл байгаагүй, Монгол Улсын иргэн байна гэж тус тус заасан.

Нэр дэвшигч нь хуульд заасан Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд тавьсан шаардлагыг хангаж байна гэж үзэн Өвгөнхүүгийн Гэрэлт-Одыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлж байна аа.

Уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Ц.Даваасүрэн: Нэр дэвшигчийн тайлангийн сонсголыг сонсгол даргалагч Улсын Их Хурлын гишүүн Заяабал танилцуулна. Заяабал гишүүний микрофоныг өгье.

Б.Заяабал: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь

хэсгийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд Өвгөнхүүгийн Гэрэлт-Одыг дэвшүүлсэн.

Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсголыг зохион байгуулахтай холбогдуулан дараах ажиллагааг явуулсан болно.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйл. Мөн хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, 131.2 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулахаар товлож, 14 хоногийн хугацаанд сонсголд оролцогчийг бүртгэх болон нэр дэвшигчээс асуух асуулт, нэр дэвшигчийн талаарх саналыг хүлээн авахаар сонсголын зарыг олон нийтэд хүргэсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал даргалж, сонсголд Төсвийн байнгын хорооны гишүүд нэр дэвшигч Гэрэлт-Од болон зарын дагуу бүртгэгдсэн нэг оролцогч оролцлоо.

3.Нэр дэвшигчийн сонсголд сонсгол даргалагч нэр дэвшигчийн талаарх товч танилцуулж, үүний дараа нэр дэвшигч уг албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшигчийн нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа танилцуулж дууссаны дараа оролцогч Байнгын хорооны гишүүн нэр дэвшигчээр нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлсэн болно оо.

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшигч У.Гэрэлт-Одыг тухайн албан тушаалд тавигдах шаардлага хангасан гэж үзсэн болно оо.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Заяабал гишүүнд баярлалаа. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшүүлсэн нэр дэвшигчийн сонсголын тайлантай холбогдуулан асуух асуулттай, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна аа гишүүд. Санал хураалтдаа бэлтгэе. Энэ бэлэн болсон уу тэгээд. Энэ чинь бас будилаантай эд юмаа. Минийх бэлэн болоогүй л байх шиг байна. Уг нь тийм л дээ. Тэгэхдээ энэ нөгөө яг аль дэлгэцэд гэдгийг нь солигдож гараад байх юм. Одоо бэлэн болчихож уу? За гишүүдийнх бэлэн болсон уу? За санал хураалт явуулна аа.

Өвгөнхүүгийн Гэрэлт-Одыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд томилохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 16 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 62.5 хувиар дэмжигдсэн байна аа.

Нэр дэвшигчийн санал хураалтаар дэмжигдсэн тул нэр дэвшигчийн баталгаажуулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя аа.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111.2 дахь хэсэг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2, 11.3 дахь хэсгийг тус тус үндэслэн гэж бичээрэй. Тус тус үндэслэн тэрийг нэмнэ шүү за юу. Чуулган руу ороод тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Тогтоох нь :

1.Өвгөнхүүгийн Гэрэлт-Одыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2025 оны 8 дугаар сарын .. өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоол байна аа.

Тогтоолтой холбогдуулаад санал асуух гишүүн байна уу? Алга байна уу?

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшүүлсэн санал, нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэж дууслаа.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Заяабал гишүүн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах юм байна шүү.

Хоёрдох асуудалдаа оръё.

Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлъе ээ.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан батлах нь зүйтэй гэж санал гаргасны дагуу Төсвийн байнгын хорооноос ажлын хэсэг байгуулан, Монгол Улс, Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 45.2 дахь хэсэгт заасан хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан ирүүлснийг та бүхэнд тараасан байгаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Батжаргал гишүүн ахалж байгаа тиймээ. Батжаргал гишүүнээр ахалсан ажлын хэсэг байгаа.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Төсвийн байнгын хорооны 2025 оны 16 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал гишүүн танилцуулна аа. Батжаргал гишүүн танилцуулъя.

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Тогтоолын төсөл боловсруулсан талаарх танилцуулга, тогтоолын төсөл манай гишүүдэд хүргэгдсэн. Тийм учраас Төсвийн байнгын хорооноос тогтоолын төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Манай ажлын хэсэгт Бадамсүрэн гишүүн, Батболд гишүүн, Заяабал гишүүн нар багтаж байгаа. Манай ажлын хэсэг хуралдаад хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг одоо боловсруулаад, Байнгын хороондоо оруулж ирж байна.

Уг тогтоолын төсөлд Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох гурилын хангалт, аюулгүй байдлыг хангах үүднээс хүнсний улаан буудайн стратегийн нөөцөд шаардлагатай 100 мянган тонн улаан буудайг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх, баруун бүс нутгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх, гурил тэжээлийн үйлдвэрлэл, хангамжийн тогтвортой байдлыг бий болгох төлөвлөгөө боловсруулж, Атрын 4 дүгээр аяны хүрээнд хэрэгжүүлэх, гурил үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний улаан буудайн чанарыг итгэмжлэгдсэн лавлагаа лабораторийн сорилт үр дүнд үндэслэн баталгаажуулж байх. Атрын 4 дүгээр аяныг хэрэгжүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийн үйлдвэрлэл, бүтээмжийг нэмэгдүүлэх, гурилын үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар улаан буудайн гурил үр тариаг татварын хөнгөлөлттэй таатай нөхцөлөөр экспортлогч орон болох эхлэлийг тавих.

Мөн мал амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт улаан буудайн гурилын хангамж нийлүүлэлт тасалдах, хомсдохоор орсон санагдаад байсан чинь яагаад тасалдахаар ороод ирэв. Үндэслэлгүйгээр үнэ өссөнийг эрх бүхий байгууллагаас тогтоосныг үйлдвэрлэгчдэд мэдэгдэх, үйлдвэрлэгчдийн зүгээс холбогдох арга хэмжээ аваагүй бол Монгол Улсын Засгийн газраас гурил, малын тэжээлийн гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж, яаралтай горимоор хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ийм зохицуулалтыг тогтоолын төсөлд тусган орууллаа.

Саяын сүүлийн хэлсэн тогтоол бол ер нь энэ манай гурил үйлдвэрлэгч нарын бас нэг хариуцлага, сахилгыг хангахтай холбоотой заалт болж тусгагдаж орж ирж байгаа юмаа. Хаа хаанаа бас нэг нийгмийнхээ өмнө хүлээх хариуцлага сахилгатай байх ёстой гэдэг үүднээс тусгасан гэдгийг хэлмээр байна.

Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүгдээсээ хүсэж байна аа. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүнд баярлалаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу? За кнопоо нэрээ өгье. Ганбаатар гишүүн. Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Энэ тогтоол ч бас нэлээн л зовж байж гарч байна шүү. Хууль нь ч одоо буцаж орж гараад тиймээ. Тэгээд энэ хуучин улсын стратегийн нөөцөд шаардлагатай улаан буудайн нөөцийг 100 мянган тонн гэж гарсан. Өмнө нь хэд байсан юм. Хэд байсныг одоо 100 мянган тонн болгож байгаа юм.

Хоёр дахь асуудал нь тэр алслагдсан бүс нутгийн гурил тэжээлийн үйлдвэрлэл хангалтыг хэвийн түвшинд хүртэлх хугацаанд үнийн өсөлтөд голлон нөлөөлж буй тээврийн зардлыг бууруулах. Тэгээд энэ тээврийн зардлыг бууруулах гэдгийгээ яаж бууруулъя гэж ийм заалт оруулж ирж байгаа юм. Бид нар чинь чөлөөт

өрсөлдөөний зах зээл дээр ажиллаж амьдарч байгаа улсууд биз дээ. Тээврийн зардлыг нь бууруулах гэдгийг нь би сайн ойлгосонгүй. Энэ 2 асуулт байна.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүн хариулъя микрофон өгье.

Ж.Батжаргал: Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол гэж тогтоол батлагдаж, энэ хүрээнд хүн амын хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн буюу стратегийн бүтээгдэхүүн, улаан буудай, гурилын асуудлыг тодорхой нөөцтэй байлгах ёстой юмаа. Ган гачиг ч гэж юм байна, гадаад нөхцөл байдал ч хүндэрнэ гэж юм байна. Ямар ч тохиолдолд хүн ам маань тэргүүн ээлжид гурилтайгаа байх ёстой гэдэг энэ зорилтыг дэвшүүлж, жилд хэрэглэх дотоодын хэрэгцээний 3-ны 1 буюу 100 мянган тонн одоо улаан буудайг улсынхаа стратегийн нөөцөд авч байх ёстой гэдэг ийм чиглэл гарсан юм. За энэний дагуу явсан. Гэхдээ өнөөдөр 100 мянгад хүрээгүй байгаа. Энүүнийг гүйцээж авах ёстой гэдэг ийм зорилгын үүднээс энэ заалтыг оруулсан гэдгийг зориуд нэгдүгээрт хэлмээр байна гэж.

Баруун бүс нутаг төвөөсөө мянга гаруй километрт алслагдсан. Энэ гурил, малын тэжээлийн үнийн өсөлт үндсэндээ тээвэр ложистик дээрээ байгаад байгаа юмаа. Энд биднүүс 60 мянгаар гэдэг юм уу одоо борлогдож байгаа 25-ын ууттай гурил тэнд 100 гаран мянгатай болчихоод больж өгөхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг энэ гол одоо үнийн өсөлтөд нөлөө үзүүлээд байгаа тээврийн зардлыг бууруулахтай холбоотой бодлогын зохицуулалтыг хий л гэж байгаа юм. Яг ний нуугүй үнэнийг хэлэхэд. Сөрөг тээвэргүй болго нэгдүгээрт, хоёрдугаарт, тээвэр ложистикийнхоо асуудлыг зөв зохицуул, шаардлагатай бол тээврийн зардал дээр нь тодорхой хэмжээний дэмжлэг үзүүл. Тэгж байж иргэд бас нэг зохистой ойролцоо үнэтэй гурил, будаагаа хэрэглээд байх бололцоо нь бүрдэх юм гэж.

Нөгөө талаасаа тухайн бүс нутгийн хилийн боомтоор тодорхой хэмжээний гурил тэжээлийг нь оруулж ирж, үнийн тогтвортой байдлыг хангах бололцоо байгаа. 2023 оны 12 сард Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос байгаль цаг уурын нөхцөл байдалтай уялдуулаад гаргасан шийдвэр дотор бол Боршо боомт, Цагаан нуур боомтуудаар тодорхой хэмжээний гурил тэжээл оруулж ирэх ийм чиглэл өгөгдсөн. Энэний дагуу явагдаад бас энэ гаалийн албан татвар чөлөөлсөнтэй холбогдоод, баруун бүс нутгийн гурилын үнэ 40 гаруй хувиар буурсан байдаг юм.

Тийм учраас тэнд нэг 24 орчим мянган тонн гурилын хэрэглээ байгаад байгаа юм. Жишсэн нормоороо. Тэрүүний тодорхой хэсгийг нь одоо цаанаас нь оруулаад ирчих юм бол энд одоо хангалт, үнийн тогтвортой байдалд их том боломжийг бий болгох юмаа гэж. Дан ганц нэг зүйлээр оролдолгүй тал талаас нь анхаарч байж тэр бүс нутгийн гурилын тэжээлийн хангалт, үнийн тогтвортой байдлыг зохицуулах ёстой гэсэн ийм чиглэлээр энэ заалт орж байгаа юм гэж.

Ц.Даваасүрэн: Тодруулъя Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Ер нь бол сая энэ хууль чинь унаж босоод байсан шалтгаан чинь энэ шүү дээ. Ер нь яах вэ энэ баруун бүсээс сонгогдсон гишүүд, Улсын Их Хурлын дарга эд нар л өөрсдөө энэ хуулийг унагачихсан шүү дээ. Та нар өөрсдөө бүгдээрээ л мэдэж л байгаа. Тэгээд одоо үндсэндээ хориод хоногийн дараа буцаад ороод ирж байна. Орж ирэхдээ яах вэ энэ дээр тэр тухайн бүс нутгийн хилийн

боомтоор оруулж ирж байгаа тэр квот байна уу, үнийн хяналтын тогтвортой байдлыг хангах энэ бол энэ заалт бол болж байгаа байхгүй юу.

Тээврийн зардлыг бууруулна гэдэг бол одоо боломжгүй зүйл шүү дээ. Бид нар төрөөс тэр тээврийн зардал дээр компенсац өгнө гэж байгаа бол энэ чинь ахиад хулгай луйвар явна. Тэр зөв. Улсын жилийн хэрэгцээний 3-ны 1 нь байна уу, тодорхой хэмжээний стратегийн нөөцөд байх шаардлагатай улаан буудайн нөөцөд бол байх шаардлагатай. Гэхдээ 100 мянган тонн гэдэг тоо яаж гарсан юм бэ, өмнө нь хэд байсан юм бэ л гэж асуусан юм л даа. 50 байсан юм уу, хэд байсан юм. Ингээд шууд хатуу 100...

Ц.Даваасүрэн: Нөөцийн хэмжээ юм шиг байна тиймээ. Батжаргал гишүүн нэмэх үү? Тийм байх ёстой. Тэгээд хүрдэггүй л юм байна шүү дээ...

Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Социализмын үед бид баруун бүс нутгийнхаа гурил тэжээлийн хангалтын тодорхой хэсгийг тэндээ үйлдвэрлэж байсан юм. Атрын 4 дүгээр аяны хүрээнд тэрнийгээ сэргээ гэдгийг энэ тогтоол дотор бүр яг зааж өгсөн. Тэгэхээр энэ асуудал жилээс жилд буурах хэлбэрээр явна. Ойлгож байна уу. Дотоодоосоо хэрэгцээгээ хангагдана гэсэн үг байхгүй юу. Тэр хүртэл тодорхой зохицуулалт хийх хэрэгтэй юм байна. Нэгэнт бид дотоодын үйлдвэрлэлээ дэмжинэ ээ гэж байгаа бол энд үйлдвэрлэсэн гурилаасаа тийшээгээ тодорхой хэмжээний гурил очих хэрэгтэй болж байна. Тэр нь тэр үнэ, үнэ өндөрсгөөд байгаа гол асуудал дээрээ бас тодорхой хөнгөлөлтийн зарчим баригдах ёстой гэдэг энэ зарчим байна.

Цаанаас нь оруулж ирэх асуудал байна. Энэ хоёр нийлнэ. Тэр 100 мянга гэдэг тоо бол ерөөсөө нийт хэрэглээний чинь 3-ны 1-ээ. Тийм учраас энэ 100 мянга гэдэг тоо яг энэ үгээрээ манай бүх баримт бичгүүдэд тусаж ороод явж байгаа тоо гэдгийг одоо зориуд хэлмээр байна аа. Бид чинь угтаа нэг 340 мянган тонн улаан буудай...

Ц.Даваасүрэн: Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Гишүүд үг хэлж, асуулт асууж дууссан тул хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Бэлэн байгаа юу, бэлтгэх ёстой юу.

Санал хураалтдаа бэлтгэе эхлээд. Татаас өгөхөд жоохон хүндрэлтэй хүндрэлтэй. Гишүүд ээ анхаараарай. Бэлэн болсон болбол санал хураалт явуулъя.

Энэ тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 16 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ.

Тогтоолын төсөл дэмжигдсэн тул Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, хууль санаачлагч Ж.Батжаргал гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тогтоолыг хэлэлцэж дууслаа.

Яаравчлан богино хугацаанд тогтоолын төслийг бэлтгэж танилцуулсан Батжаргал гишүүнтэй ажлын хэсэгт талархал илэрхийлье.

Мөн сонсголыг одоо амжилттай зохион байгуулсан Заяабал гишүүнд бас талархал илэрхийлье ээ.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууслаа. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ